



**Инженер техникийн  
хэсгийн 5 дугаар сарын  
үйл ажиллагааны тайлан**

**2023.06.07**




# 1. Захиалагчийн хяналт:

- Нийтийн зориулалттай орон сууцны барилгын 18 цахилгаан шатны шинэчлэлийн ажил 2022-2023 оны дамжин хэрэгжиж байна.  
Үүнээс – “Фүшили элеватор” ХХК 2 лифт улсын коммист хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.  
“Төвхөн трейд” ХХК 5 лифт улсын комисст хүлээлгэн өгөөд комиссын акт баталгаажих шатандаа явж байна. 1 лифтний угсралтын ажил нь явагдаж байна.  
“Оакс экспресс монголиа” ХХК 10 лифт улсын комисст хүлээлгэн өгөөд комиссын акт баталгаажих шатандаа явж байна.  
“Оакс экспресс монголиа” ХХК-тай 4 лифтний гэрээ байгуулан НЗДТГ-т хүргүүлээд байна.



## 2. Засвар, техник үйлчилгээ:

- Гэрээт 53 ААНБ, СӨХ-дын 163 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийхээс 53 ААНБ, СӨХ-дын 155 лифт, мөн гүүрэн гарцийн 8 лифт, нийт 163 лифтэнд засвар, техник үйлчилгээг хийлгэж, механикуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж бүртгэл хөтөлж ажилласан.
- Гэрээт ААНБ, СӨХ-доос нийт 26 дуудлага ирснийг цаг хугацаанд нь засварлан лифтүүдийг хэвийн ажиллагаанд оруулсан.



### 3. Гүүрэн гарц

- 100-айлын гүүрэн гарцны лифтний урд болон хойд талын аюулгүйн гар тоормос, урд талын 1 болон 2 давхрын гэрлэн мэдрэгч, хойд талын 2 давхрын гадна дуудлаганы кноп, тормосны контакт зэргийг сольж ажиллагаанд оруулсан.
- Бөмбөгөрийн гүүрэн гарцны лифтний баруун талын лифтний гулсах башмаг сольсон.
- Явган хүний 4 гүүрэн байгууламж болон цахилгаан шатуудын арчлалт, цэвэрлэгээ хийсэн байдалд үзлэг шалгалтыг 2023.05.11 нд хийж гүйцэтгэсэн.



## 4. Техникийн магадлал

- Гэрээт болон гэрээт бус СӨХ-ны хүсэлтийн дагуу “Шинэ хангай” СӨХ-ны 20 лифт, “Цоглог” СӨХ-ны 4 лифт, “Равсал” ХХК 4 лифт, “Очир 72” СӨХ-ны 2 лифт, “Хүннү вилла” СӨХ-ны 12 лифт “Саруул шилтгээн” ХХК 2 лифт, “Драгон” ХХК-ны 17 лифт, “Галын дөл” СӨХ-ны 7 лифт, нийт 67 лифтэнд техникийн ээлжит магадлалын ажлыг Механик инженер Я.Батбаатар, Хяналтын инженер Б.Батзориг, Хяналтын инженер Б.Байгаль нар хийж гүйцэтгэн, актыг үйлдэж СӨХ-дод хүргүүлсэн.



## 5.Бусад ажил

### Албан бичиг

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем

<https://erp.ulaanbaatar.mn/>

нэгдсэн сайтаар ИТХ-т нийт **20** албан бичиг ирсэн байна.

Хяналтын инженер Ц.Уранбилэг **7**, Хяналтын инженер Б.Байгаль **6**, Механик инженер Я.Батбаатар **7** албан бичгийн тус тус шийдвэрлэсэн байна.

### Спортын арга ХЭМЖЭЭ

2023 оны 05 дугаар сарын 05-с 07-ний өдрийн хооронд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнд идэвхтэй хамрагдсан.

### Мод тарих аян

Ойн тухай хууль, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг зохион байгуулагдаж байгаа тул Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын аманд хэрэгжүүлж буй ойжуулалтын талбайн А хэсэгт батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр мод тарих, цэнэг усалгаа, нөхөн тарилт хийх ажилд оролцсон.





**Анхаарал хандуулсанд баярлалаа**